

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн IX Бага хурлаар батлав.

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Ерөнхий зүйл

- 1.1 Монголын Эрчим хүч, Геологи, Уул уурхайн Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо (цаашид салбарын ҮЭ-ийн холбоо гэнэ) нь гишүүдийнхээ хөдөлмөрлөх эрхийг хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах зорилгоор сайн дурын үндсэн дээр эрчим хүчний үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгчид, металл болон металл биш эрдэс, газрын тос, химийн түүхий эд, эрдэс баялгийг цэвэршүүлж, хийн түлш боловсруулах ажилчид, нүүрсний ил ба гүний уурхайчид, геологичид болон тэдгээртэй хамаарал бүхий ажилчдын мэргэжил-үйлдвэрлэлийн шинжээрээ эвлэлдэн нэгдсэн хөдөлмөрчдийн бие даасан нэгдэл мөн.
- 1.2 МЭХГУУ-н ҮЭ-ийн холбооны оноосон нэр нь: Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо”, хураангуйлснаар “МЭХГУУ-н ҮЭ-ийн холбоо” буюу “МЭХГУУҮЭХ”, англи хэлээр “Federation of Mongolian energy, geology and mining trade unions”, хураангуйлснаар “MEGM” гэж байна.
- 1.3 Салбарын ҮЭ-ийн холбоо нь хуулийн этгээд мөн бөгөөд туг, тамга, онцлох тэмдэг, албан бичгийн хуудас, уриа, шагнал, хэвлэлтэй байна.
- 1.4 Салбарын ҮЭ-ийн холбоо нь гишүүдийнхээ нийгэм, эдийн засгийн эрх, ашиг сонирхолыг төлөөлөн хамгаалах, гишүүд, хөдөлмөрчдөд үйлчлэх зорилтыг үйл ажиллагааны үндсэн чиг баримтлал болгон салбарын үндсэн нэгжийн ҮЭ-ийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, эв нэгдлийг бэхжүүлэхэд бүх талын туслалцаа үзүүлнэ.
- 1.5 Салбарын ҮЭ-ийн холбоо нь өөрийн бодлого үйл ажиллагаагаа төр засаг, аж ахуйн нэгж байгууллага, улс төрийн нам, холбоо, олон нийтийн хөдөлгөөнөөс хараат бус, бие дааж чөлөөтэй явуулах бөгөөд тэдэнтэй тэгш эрх, гэрээ, хэлэлцээр, түншлэлийн үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн гишүүдийнхээ эрх, ашиг сонирхлыг урьтал болгон хамтран ажиллана.
- 1.6 Салбарын ҮЭ-ийн холбоо нь Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг, МҮЭ-ийн ордонд байрлана.
- 1.7 Салбарын ҮЭ-ийн холбоо нь Монгол Улсын “Үндсэн хууль”, “ҮЭ-үүдийн эрхийн тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, олон улсын гэрээ конвенц, энэхүү дүрэм болон МҮЭ-ийн холбооны дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЗАРЧИМ

Хоёрдугаар зүйл. Эрхэм зорилго

- 2.1 Салбарын ҮЭ-ийн холбооны эрхэм зорилго эрчим хүч, геологи, уул уурхайн салбарын ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хөдөлмөрийн нөхцөл, амьдралын түвшинг сайжруулна.

Гуравдугаар зүйл. Зорилтууд

- 3.1 Салбарын ҮЭ-ийн холбоо эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд дор дурдсан зорилтуудыг хэрэгжүүлнэ.
 - 3.1.1 Гишүүдийнхээ цалин хөлсийг хүн амын бодит хэрэгцээг хангахуйц түвшинд хүртэл нэмэгдүүлэхийн төлөө тэмцэх
 - 3.1.2 ҮЭ-ийн гишүүд, ажилтны сургалт, давтан сургалтыг өргөжүүлэх, ҮЭ-ийн гишүүдэд, хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх
 - 3.1.3 Хөдөлмөрийн стандартууд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг ажлын байр, үйлдвэрлэлийн орчинд хангуулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулах талаар идэвхтэй нөлөөлөх
 - 3.1.4 Зохион байгуулагдаагүй ажилчдад, ялангуяа хувийн секторт бие даасан ардчилсан ҮЭ-ийн байгууллага байгуулах, ҮЭ-ийн эгнээг өргөтгөх
 - 3.1.5 Хөдөлмөрчдийн эвлэлдэн нэгдэх, хэлэлцээ хийх, ажил хаялт зохион байгуулах зэрэг үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулах, үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн дэх ардчилсан ололт, амжилтыг бататгах үндсэн дээр үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний хүч чадал, дотоод ардчилал, эв нэгдлийг бэхжүүлэх
 - 3.1.6 Гишүүн байгууллагуудынхаа тэгш эрхийг хангаж бие даасан байдлыг бүх талаар дэмжиж туслах
 - 3.1.7 ҮЭ-ийн үйл ажиллагаанд залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг идэвхжүүлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад идэвхтэй оролцох
 - 3.1.8 Хүнд суртал, авилга, хээл хахуулийн эсрэг тэмцэх, нийгмийн түншлэлийн тогтолцоог хөгжүүлж салбарын төвшинд гурван талт хамтын хэлэлцээр, холбооны гишүүн байгууллага, ҮЭ-ийн хороод нь ажилчдын цалин орлого, ажил амралтын цаг зэрэг хөдөлмөр нийгмийн харилцаатай холбоо бүхий асуудлуудыг хамтын гэрээ, хэлэлцээрээр шийдвэрлэдэг байгууллага болох
 - 3.1.9 Хөдөлмөрлөх эрх түүнтэй холбогдсон ашиг сонирхолыг хамгаалах талаар хуулийн төсөл боловсруулахад санаачлагатай оролцох
 - 3.1.10 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих төрийн хяналтыг хүчтэй болгоход нөлөөлж, үйлдвэрчний эвлэлийн үндэсний хэмжээний хяналтыг зохион байгуулахад оролцох
 - 3.1.11 Хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулахад оролцож, хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан, ажил хаялт пикет болон хамтын тэмцлийн бусад ажиллагааг зохион байгуулж, үйлдвэрчний эвлэлийн хамтын тэмцэл, үйл ажиллагааг дэмжих
 - 3.1.12 Үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн, хөдөлмөр-нийгмийн асуудлаар бие дааж болон бусад байгууллагуудтай хамтран судалгаа, дүгнэлт хийх
 - 3.1.13 Өөрийн салбарын цахим мэдээллийн сүлжээ, хэвлэл мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх
 - 3.1.14 Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, ҮЭ-ийн санхүүг арвижуулах
 - 3.1.15 Олон улсын болон гадаад орны үйлдвэрчний эвлэлүүд, Олон улсын Хөдөлмөрчдийн байгууллага, сангуудтай хамтран ажиллах

Дөрөвдүгээр зүйл. Зарчим

- 4.1 Салбарын ҮЭ-ийн холбоо, түүний гишүүн байгууллагууд нь үйл ажиллагаандаа дор дурдсан зарчмуудыг баримталж ажиллана. Үүнд:
 - 4.1.1 МҮЭ-ийн холбооны дүрэм, МЭХГУУ-н ҮЭ-ийн холбооны дүрэм, журмуудыг баримтлан ажиллана.
 - 4.1.2 Улс төрийн нам, Засгийн газар, ажил олгогчид болон бусад этгээдүүдээс хараат бус байж, үйл ажиллагаагаа чөлөөтэй, бие даан явуулна.
 - 4.1.3 Бодлого, шийдвэр үйл ажиллагаа үйлдвэрчний эвлэлийн анхан шатны байгууллага болон гишүүдэд ил тод, нээлттэй байна.

- 4.1.4 Өөрийгөө удирдан санхүүжүүлнэ.
- 4.1.5 Засгийн газар, ажил олгогчдын байгууллага, бусад байгууллагуудтай нийгмийн түншлэлийн зарчмыг удирдлага болгон хамтран ажиллана.
- 4.1.6 Шийдвэр гаргах үйл ажиллагаандаа хамтын удирдлагын зарчмыг баримтална.
- 4.1.7 Зохист хөдөлмөрийн үзэл баримтлалд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА

Тавдугаар зүйл. Гишүүн байгууллага

- 5.1 Эрчим хүчний анхдагч эх үүсвэр гарган үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгчид, металл болон металл биш эрдэс, нефть химийн түүхий эд, эрдэс баялагийг цэвэршүүлж, хийн түлш боловсруулах ажилчид, нүүрсний ил ба гүний уурхайчид, геологичид болон тэдгээртэй хамаарал бүхий салбарын ажилчдыг эгнээндээ нэгтгэсэн ҮЭ-ийн үндсэн нэгжийн байгууллага нь Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны гишүүн байгууллага мөн.
- 5.2 Салбарын ҮЭ-ийн гишүүн байгууллагаар элсэх үйлдвэрчний эвлэлийн хороо нь дор дурдсан шаардлагыг хангасан байна.
 - 5.2.1 ҮЭ-ийн холбооны дүрэм, зорилго, зорилтуудыг хүлээн зөвшөөрч гишүүнээр элсэх хүсэлтийг албан ёсоор ирүүлэх бөгөөд ҮЭ-ийн хороо байгуулагдсан он сар, гишүүдийн тоо, хаягийг тодорхой заасан байна.
 - 5.2.2 Өөр ямар нэгэн мэргэжил үйлдвэрлэлийн болоод нутаг дэвсгэрийн үйлдвэрчний эвлэлийн холбоонд давхар гишүүнчлэлгүй байна. Гишүүн ҮЭ-ийн хороод орон нутагтаа харьяалагдаж болно.
 - 5.2.3 ҮЭ-ийн хороо нь гишүүдийн татвар, хандиваар санхүүжнэ.
- 5.3 Эрчим хүч, геологи, уул уурхайн болон ижил төрлийн ҮЭ-ийн гишүүдийг эгнээндээ нэгтгэсэн ҮЭ-ийн байгууллагууд нь тус холбоонд гишүүнээр элсэж болно.
- 5.4 ҮЭ-ийн холбоонд элсүүлэх, гишүүнээс хасах асуудлыг Гүйцэтгэх хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

Зургаадугаар зүйл. Гишүүн байгууллагын эрх

- 6.1 Гишүүн байгууллага буюу ҮЭ-ийн хороо нь 4 жилд 1 удаа сонгуулиа заавал явуулж бүтэц зохион байгуулалтын асуудлаа бие даан шийдвэрлэх ба эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна. Бүх гишүүдийн хурлаас үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга, тэргүүлэгчид, хяналтын хорооны дарга, гишүүдийг 4 жилийн хугацаатай сонгоно.
- 6.2 Сонгууль явуулах журмыг ҮЭ-ийн хорооны тэргүүлэгчдийн хурал эсвэл тус хурлаас батлагдсан сонгуулийн комиссоос тогтооно.
- 6.3 ҮЭ-ийн холбооны бодлого, үйл ажиллагааны чиглэл, дүрэм, хөгжлийн зорилтыг тодорхойлоход оролцоно.
- 6.4 ҮЭ-ийн холбооны бага хуралд төлөөлөгч сонгоно.
- 6.5 ҮЭ-ийн холбооны тэргүүлэгч, хяналтын хорооны дарга, гишүүдэд нэр дэвшүүлнэ.
- 6.6 МҮЭХ, салбарын ҮЭ-ийн холбооны туслалцаатайгаар гишүүд, идэвхтнээ хөнгөлөлттэй сургана.
- 6.7 ҮЭ-ийн холбооноос эрх зүйн туслалцаа хүсэх, үйл ажиллагаандаа мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа авна.
- 6.8 Төр, МҮЭ-ийн холбооны шагналд нэр дэвшигчдийг салбарын болон МҮЭ-ийн холбоогоор дэмжүүлэх тухай санал оруулна.
- 6.9 МҮЭ-ийн болон салбарын ҮЭ-ийн холбооны хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр үйл ажиллагаагаа сурталчилна.
- 6.10 ҮЭ-ийн хороо нь бүх гишүүддээ тайлангаа жил бүр тавьж 4 жилд нэг удаа сонгууль явуулах бөгөөд зайлшгүй тохиолдолд /ҮЭ-ийн хорооны орон тооны болон орон тооны

бус дарга нь өөрийн хүсэлтээр, эрүүл мэндийн шалтгаанаар, нас барсан, удирдах албан тушаалд дэвшсэн, ажлаас халагдсан эсхүл гишүүдийн олонхи сонгууль явуулахыг шаардсан нөхцөлд/ хугацаа харгалзахгүй зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх эрхтэй.

- 6.11 ҮЭ-ийн холбооноос гарах асуудлыг бүх гишүүдийн хурлын гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэж тогтоолоор баталгаажуулна. Уг тогтоолыг гишүүн байгууллагаас гарах тухай албан хүсэлтийн хамт Салбарын ҮЭ-ийн холбоонд ирүүлнэ.

Долдугаар зүйл. Гишүүн байгууллагын үүрэг

- 7.1 ҮЭ-ийн холбооны дүрмийг биелүүлж, үйл ажиллагааг дэмжинэ.
- 7.2 Салбарын ҮЭ-ийн холбооны дүрмийн дагуу гишүүн байгууллагын татварыг сар бүр /Хариуцлага үр дүнгийн гэрээнд тохиролцсоны дагуу/ салбарын ҮЭ-ийн холбоонд төвлөрүүлнэ.
- 7.3 ҮЭ-ийн холбооны Эв нэгдлийн санд хуримтлал төвлөрүүлж болно. Эв нэгдлийн сангийн зарцуулалтын журмыг Тэргүүлэгчдийн хурлаар баталж мөрдүүлнэ.
- 7.4 ҮЭ-ийн холбооны гишүүн байгууллагууд үйл ажиллагааны хувьд нэгдмэл байна.
- 7.5 ҮЭ-ийн холбооноос өгсөн үүрэг чиглэл, санал болгосон асуудлын мөрөөр зохих арга хэмжээг хэрэгжүүлж, дүнг албан бичгээр хариу мэдэгдэж хамтран ажиллана.
- 7.6 МҮЭ-ийн холбоо болон салбарын ҮЭ-ийн холбооноос зохион байгуулж байгаа хамтын үйл ажиллагаанд гишүүдээ идэвхтэй оролцуулна.
- 7.7 ҮЭ-ийн холбооны дарга, нарийн бичгийн дарга нарын зөвлөл, тэргүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, үйлдвэрчний эвлэлүүдийн эв санааны нэгдлийг хангаж ажиллана.
- 7.8 ҮЭ-ийн холбоонд тайлан мэдээг хугацаанд нь ирүүлнэ.
- 7.9 ҮЭ-ийн хороод эв санааны нэгдлийн сантай байна. Эв санааны нэгдлийн сан гишүүдийн татварын таван хувь, болон хандиваас бүрдэнэ.

Наймдугаар зүйл. Гишүүн байгууллагаас хасах

- 8.1 ҮЭ-ийн холбооны гишүүнээс гарах хүсэлтийг Гүйцэтгэх хорооны хуралдаанаас гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ.
- 8.2 Дараах тохиолдолд гишүүн байгууллагаас хасна. Үүнд:
- 8.2.1 Үндсэн байгууллага нь татан буугдсан, өөр салбар компанид нэгдсэн
- 8.2.2 ҮЭ-ийн холбооноос зохион байгуулсан үйл ажиллагаанд 1 жил буюу түүнээс дээш хугацаанд оролцоогүй
- 8.2.3 Гишүүн байгууллагаас гарах хүсэлтээ бүх гишүүдийн хурлаасаа гаргасан
- 8.2.4 Гишүүн байгууллагын татвараа 6 сарын хугацаанд төлөөгүй
- 8.3 Холбооноос гарсан, хасагдсан тохиолдолд гишүүнчлэлийн татвар, хандивыг буцааж олгохгүй.
- 8.4 Салбарын ҮЭ-ийн холбоонд 1 жилийн хугацаанд гишүүнчлэлийн татвараа төлөөгүй тохиолдолд уг ҮЭ-ийн хороог гишүүн байгууллагаас хасагдсанд тооцно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ГИШҮҮН

Есдүгээр зүйл. Үйлдвэрчний эвлэлийн гишүүн

- 9.1 Монгол улсын Үндсэн хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, энэ дүрмийн хүрээнд эрх ашгаа нэгдэж хамгаалахыг хүссэн эрчим хүч, геологи, уул уурхайн салбарт хөдөлмөрийн харилцаанд оролцож буй Монгол улсын иргэн, мөн тус улсад хуулийн дагуу оршин сууж хөдөлмөрийн харилцаанд оролцож буй гадаадын иргэн тус салбарын ҮЭ-ийн гишүүн байж болно.

- 9.2 ҮЭ-ийн гишүүнээр элсэх, гишүүнээс татгалзахдаа байгууллагынхаа ҮЭ-ийн хороонд хүсэлтээ бичгээр гаргаж ҮЭ-ийн хорооны тэргүүлэгчдийн хурлаар уг асуудлыг шийдвэрлэнэ.
- 9.3 ҮЭ-ийн гишүүнээр элсэж, гишүүний татвараа төлж эхэлснээр ҮЭ-ийн гишүүн болно.
- 9.4 ҮЭ-ийн холбооны гишүүд нэг загварын батлахтай байна.
- 9.5 ҮЭ-ийн гишүүн нь өөр салбарын ҮЭ-ийн гишүүн байж үл болно.

Аравдугаар зүйл. Үйлдвэрчний Эвлэлийн гишүүний эрх

- 10.1 ҮЭ-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлого боловсруулахад оролцох, байр сууриа илэрхийлэх
- 10.2 ҮЭ-ийн төлөөлөн удирдах байгууллагыг сонгох, тус байгууллагад сонгогдох, нэрээ дэвшүүлэх, татгалзах
- 10.3 Үзэл бодол, нэр төр, хууль ёсны эрх ашгаа хамгаалуулах, хууль зүйн зөвлөгөө авах, МҮЭ-ийн гэрээт өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх
- 10.4 Шаардлагатай үед ҮЭ-ээс хамтын гэрээ, хэлэлцээр бусад дүрэм, журамд заасны дагуу оюун санаа, эд материалын тусламж авах
- 10.5 Төрийн болон иргэдийн төлөөлөгчдийн бүх шатны байгууллагад сонгогдох эрхээ эдлэхдээ үйлдвэрчний эвлэлээс хуулийн хүрээнд мөнгөн бус дэмжлэг авах
- 10.6 МҮЭ-ийн сургалт, соёл, үйлчилгээ, амралт сувилалаар хөнгөлөлттэй үйлчлүүлэх
- 10.7 ҮЭ-д элсэх, гарах, дахин элсэх

Арваннэгдүгээр зүйл. Үйлдвэрчний Эвлэлийн гишүүний үүрэг

- 11.1 Хууль ёсыг дээдлэн сахиж, ашиг сонирхлоо хамтран хамгаалах, ҮЭ-ийн эв нэгдлийг бэхжүүлэхийн төлөө идэвхтэй тэмцэх
- 11.2 ҮЭ-ийн гишүүний татварыг сар бүр цалин хөлс түүнтэй адилтгах орлогын 1 буюу түүнээс дээш хувиар бэлэн бусаар хураалгаж, ҮЭ-ийн сан хөмрөгийг арвижуулахад идэвх санаачилгатай байх
- 11.3 Байгууллагынхаа ҮЭ-ийн хороонд харьяалагдаж ҮЭ-ийн дүрэм, үйл ажиллагааны чиг баримтлал, бодлого шийдвэрийг хамт олондоо сурталчлах, ҮЭ-ийн эгнээг өргөжүүлэхэд оролцох
- 11.4 Төр засгийн болон Монголын ҮЭ-ийн бүх шатны байгууллагад нэр дэвшсэн, сонгогдсон, томилогдсон МҮЭ-ийн гишүүн хүмүүсийг дэмжиж ажиллах
- 11.5 МЭҮХ, ҮЭ-ийн холбооноос зохион байгуулсан хурал, уулзалт, ярилцлага, жагсаал, цуглаан зэрэг нийтийг хамарсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцох

Арванхоёрдугаар зүйл. Үйлдвэрчний эвлэлийн сонгуульд
ажилтан, гишүүдийн ёс зүй

- 12.1 ҮЭ-ийн анхан шатны хорооныхоо бүх гишүүдийн буюу төлөөлөгчдийн хурлаас сонгогдсон орон тооны болон орон тооны бус ҮЭ-ийн хорооны дарга, тэргүүлэгчид, нягтлан бодогч, хяналтын хорооны дарга, гишүүд, эмэгтэйчүүдийн хэсгийн дарга, залуучуудын хэсгийн дарга, хөдөлмөр хамгааллын итгэмжлэгдсэн төлөөлөгч, тэргүүлэгчээр сонгогдсон ҮЭ-ийн гишүүнийг сонгуульд ажилтан гэнэ.
- 12.2 ҮЭ-ийн сонгуульд үүргээ гэр бүлийн болон хувийн санхүүгийн байдлаа дээшлүүлэхэд ашиглахгүй байх
- 12.3 ҮЭ-ийн сонгуульд ажилтан ҮЭ-ийн шууд болон удирдах дээд байгууллагын бодлого, шийдвэрийг мушгин гуйвуулахгүй биелүүлж ажиллах
- 12.4 МҮЭ-ийн холбооны дүрэм, салбарын ҮЭ-ийн холбооны дүрэм болон бусад дүрэм, журмыг сахин биелүүлж ҮЭ-ийн эв нэгдлийг хангаж, биелүүлж ажиллах

- 12.5 Гишүүдийнхээ хөдөлмөрлөх эрхийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах
- 12.6 Хууль зөрчсөн, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх
- 12.7 Ажил үүргээ гүйцэтгэхдээ иргэд, ҮЭ-ийн гишүүд, хамтран ажиллагсадтайгаа эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, ҮЭ-ийн үйл ажиллагааг аливаа чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх
- 12.8 ҮЭ-ийн гишүүдээс ирсэн санал гомдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу барагдуулж, хүнд суртал чирэгдэл гаргахгүй байх
- 12.9 ҮЭ-ийн эрхийн болон хөдөлмөрийн харилцааны зөрчил дутагдлыг нуун дарагдуулахгүй байх, эрх бүхий албан тушаалтанд мэдээлэх

ТАВДУГААР БҮЛЭГ. ЭРХ БАРИХ БОЛОН УДИРДАХ БАЙГУУЛЛАГА

Арвангуравдугаар зүйл. Бага хурал

- 13.1 Салбарын ҮЭ-ийн холбооны эрх барих дээд байгууллага нь ҮЭ-ийн холбооны Бага хурал (цаашид “Бага хурал” гэх) байна. Бага хурлыг 4 жил тутамд хуралдуулна.
- 13.2 Бага хурлын тов, хэлэлцэх асуудлыг бага хурал хуралдахаас нэгээс доошгүй сарын өмнө Тэргүүлэгчдийн хурлаас тогтоож зарлана.
- 13.3 Бага хуралд сонгох төлөөлөгчдийн тоог гишүүдийн нэрчилсэн бүртгэлийг үндэслэн тогтоох бөгөөд нэг төлөөлөгчийн төлөөлөх гишүүдийн тоо, төлөөлөгч сонгох журам, бага хурал зохион байгуулах хороо, сонгуулийн мандатын комисс тэдгээрийн ажиллах дүрэм, журмыг салбарын ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлаар батална.
- 13.4 ҮЭ-ийн холбооны гишүүн байгууллагуудын гуравны хоёроос доошгүй нь албан ёсоор шаардсанаар Ээлжит бус бага хурлыг хугацаанаас нь өмнө зарлан хуралдуулж болно. Шаардлага тавигдсанаас хойш Ээлжит бус бага хурлыг 3 сарын дотор салбарын ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлаас зарлан хуралдуулна.
- 13.5 Бага хуралд сонгогдсон төлөөлөгчдийн дөрөвний гурваас доошгүй нь ирсэн тохиолдолд бага хурлыг хүчин төгөлдөр гэж үзнэ.
- 13.6 Бага хурлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүний 50-иас доошгүй хувь нь эмэгтэйчүүд, залуучуудын төлөөлөл байх бодлого баримтална.

Арвандөрөвдүгээр зүйл. Бага хурлын бүрэн эрх

- 14.1 Бага хурал нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 14.1.1 ҮЭ-ийн холбооны болон Хяналтын хорооны тайланг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгөх
 - 14.1.2 ҮЭ-ийн холбооны болон Хяналтын хорооны дүрэм, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэж батлах
 - 14.1.3 ҮЭ-ийн холбооны зорилт, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг батлах
 - 14.1.4 ҮЭ-ийн холбооны дарга, Гүйцэтгэх хорооны гишүүдийг сонгож батлах
 - 14.1.5 МҮЭ-ийн холбооны Их хурлын төлөөлөгч, Ерөнхий зөвлөлийн гишүүдийг сонгох /МҮЭ-ийн Их хурлын жилээс салбарын ҮЭ-ийн холбооны Бага хурлын жил зөрөх тохиолдолд МҮЭХ-ны Их хурлын төлөөлөгч сонгох эрхээ Гүйцэтгэх хорооны хуралд шилжүүлнэ. /
 - 14.1.6 Хяналтын хорооны гишүүдийг сонгох, Хяналтын хорооны гишүүдийн саналаар Хяналтын хорооны даргыг батлах
 - 14.1.7 ҮЭ-ийн холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах

14.2 Бага хурал нь энэхүү дүрэмд зааснаас бусад тохиолдолд Бага хуралд оролцсон төлөөлөгчдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэж, тогтоол гаргаж болно.

Арвантавдугаар зүйл. Гүйцэтгэх хорооны хуралдаан

- 15.1 Бага хурлын хооронд ҮЭ-ийн холбооны удирдах дээд байгууллага нь тус холбооны Гүйцэтгэх хорооны хуралдаан байна.
- 15.2 Гүйцэтгэх хорооны хуралдааны гишүүд нь дарга, нарийн бичгийн дарга, эмэгтэйчүүдийн хорооны дарга, залуучуудын хорооны дарга болон гишүүн байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ. Гишүүн байгууллагын төлөөлөл нь ҮЭ-ийн хороодын дарга нар байна.
- 15.3 Гүйцэтгэх хорооны хуралдаанд сонгогдох ҮЭ-ийн холбооны гишүүн байгууллагын төлөөлөл нь гишүүн байгууллагуудын дөрөвний нэгээс хэтрэхгүй байна.
- 15.4 Гүйцэтгэх хорооны хуралдааныг жилд нэгээс доошгүй удаа Тэргүүлэгчдийн хурлаас зарлан хуралдуулна.
- 15.5 Гүйцэтгэх хорооны хуралдааныг уг хуралдааны нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн шаардлагаар хуралдуулж болно.
- 15.6 Гүйцэтгэх хорооны хуралдааны нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчин төгөлдөр гэж үзнэ.
- 15.7 Гүйцэтгэх хорооны хуралдааныг салбарын ҮЭ-ийн холбооны дарга удирдана.
- 15.8 ҮЭ-ийн хорооны даргын дүрмийн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал, татвар төвлөрүүлэлт, эв нэгдлийг хангах, манлайлал зэргийг харгалзан ажлын албанаас Гүйцэтгэх хорооны гишүүдэд нэр дэвшүүлж Бага хурлаар хэлэлцүүлнэ.
- 15.9 ҮЭ-ийн холбоонд татвараа төлөөгүй гишүүн байгууллагын төлөөлөл эрхийг хязгаарлана.

Арванзургаадугаар зүйл. Гүйцэтгэх хорооны хуралдааны эрх үүрэг

- 16.1 Гүйцэтгэх хорооны хуралдаан нь дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 16.1.1. ҮЭ-ийн холбооны салбар хариуцсан нарийн бичгийн дарга нар, тэргүүлэгчдийг сонгож батлах, чөлөөлөх, нөхөн сонгох
 - 16.1.2. ҮЭ-ийн холбооны бодлого, бүтэц, зохион байгуулалтын асуудлуудыг хэлэлцэж тогтоол гаргах
 - 16.1.3. ҮЭ-ийн холбоонд гишүүнээр элсүүлэх, хасах, гишүүнээс гарах асуудлыг шийдвэрлэх
 - 16.1.4. ҮЭ-ийн холбооны жилийн санхүүгийн тайлан, төсвийг хэлэлцэж батлах
 - 16.1.5. Гүйцэтгэх хорооны гишүүд, Хяналтын хорооны гишүүдийг батлах, чөлөөлөх, нөхөн сонгох
 - 16.1.6. Хяналтын хорооны мэдээлэлтэй танилцах, үйл ажиллагааны зардлыг батлах.
 - 16.1.7. Салбарын ҮЭ-ийн холбооны дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас бүрэн эрхийнхээ хугацаанаас өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан болон эрүүл мэндийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болох нь эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, орлон ажиллах албан тушаалтныг томилж

Арвандолоодугаар зүйл. Тэргүүлэгчдийн хурал

- 17.1 Гүйцэтгэх хорооны хуралдааны хооронд ҮЭ-ийн холбооны дээд удирдлагыг тэргүүлэгчдийн хурал хэрэгжүүлнэ. Тэргүүлэгчдийн хурлыг салбарын ҮЭ-ийн холбооны дарга удирдана.
- 17.2 Тэргүүлэгчдийн тоо бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх хорооны хурлаас тогтооно.
- 17.3 Тэргүүлэгчдийн хурал нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүн байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд эмэгтэйчүүд, залуучуудын төлөөллийг хангах бодлого баримтална.

- 17.4 Тэргүүлэгчдийн хурлыг улиралд нэгээс доошгүй удаа салбарын ҮЭ-ийн холбооны дарга зарлан хуралдуулна.
- 17.5 Тэргүүлэгчдийн гуравны хоёроос доошгүй нь ирсэн бол хурлыг хүчин төгөлдөр гэж үзнэ.

Арваннаймдугаар зүйл. Тэргүүлэгчдийн хурлын эрх, үүрэг

- 18.1 Тэргүүлэгчдийн хурал нь дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 18.1.1 Гүйцэтгэх хорооны хуралдааныг зарлан хуралдуулах, уг хурлаар хэлэлцэх асуудлыг тогтоох
- 18.1.2 ҮЭ-ийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж тогтоол гаргах
- 18.1.3 Ажлын албаны бүтэц зохион байгуулалт, ажилтнуудын цалинг шинэчлэн батлах,
- 18.1.4 Монгол улсын хууль, гэрээ, конвенц болон МҮЭ-ийн холбооны шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журам, дүрэм, заавар батлах
- 18.1.5 Салбарын ҮЭ-ийн холбооны дүрмийг зөрчсөн гишүүн байгууллага, сонгуульт ажилтанд зөвлөгөө, чиглэл өгөх, хариуцлага тооцох
- 18.1.6 ҮЭ-ийн холбооны өмч, хөрөнгө санхүүг ашиглахтай холбоотой шийдвэр гаргах
- 18.1.7 Салбарын ҮЭ-ийн холбооны тэргүүлэгчид нь МҮЭ-ийн холбоо, салбарын ҮЭ-ийн холбооны Бага хурал, Гүйцэтгэх хорооны хуралдаанд хамтын хариуцлага хүлээх
- 18.1.8 ҮЭ-ийн хороодын үйл ажиллагаанд баримтлах чиглэл боловсруулах, үнэлэх, үйл ажиллагааг нь дэмжих
- 18.1.9 Хяналтын хорооны шалгалт хийх хуваарь, үйл ажиллагаа явуулахтай холбоотой зардлыг Гүйцэтгэх хорооны хуралдаанаас батлагдсан төсвийн хүрээнд Тэргүүлэгчдийн хуралдаанаар тогтоох
- 18.1.10 ҮЭ-ийн холбооны гадаад харилцаа, олон улс дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх
- 18.1.11 Салбарын ҮЭ-ийн холбооны дарга зайлшгүй шалтгааны улмаас бүрэн эрхийнхээ хугацаанаас өмнө чөлөөлөгдөх, хүсэлтээ өөрөө гаргасан буюу ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн, ҮЭ-ийн хууль, дүрэм, зөрчсөн зэрэг шалтгаанаар хугацаанаас нь өмнө огцруулах тухай гишүүн байгууллагуудын гуравны хоёроос доошгүй нь албан ёсоор шаардвал Тэргүүлэгчид хуралдаж ээлжит бус бага хурал зарлан хуралдуулж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. УДИРДАХ БА ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН

Арванесдүгээр зүйл. Салбарын ҮЭ-ийн холбооны дарга

- 19.1 ҮЭ-ийн холбооны бага хурлын төлөөлөгчид саналаа илээр буюу нууцаар хурааж олонхийн санал авсан нэр дэвшигчийг 4 жилийн хугацаагаар даргаар сонгоно. Тэргүүлэгчдийн хурал эсвэл уг хурлаас байгуулагдсан ажлын хэсэг сонгууль явуулах журмыг тогтооно.
- 19.2 Нэг нэр дэвшигчтэй байвал илээр, 2 болон түүнээс дээш нэр дэвшигчтэй бол нууцаар санал хураана.
- 19.3 Салбарын ҮЭ-ийн холбооны даргын сонгуульт албан тушаалд дээд боловсролтой, тухайн салбарын онцлог, үйл ажиллагааны талаар мэдлэг туршлагатай, үйлдвэрчний эвлэлийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалд 8-аас доошгүй жил ажилласан, хөдөлмөрийн насны үйлдвэрчний эвлэлийн гишүүнийг сонгож ажиллуулна.
- 19.4 Бага хурлын бүрэн эрхийн хугацаанд ҮЭ-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, дүрмийн хүрээнд тогтвортой ажилласан туршлага бүхий ҮЭ-ийн гишүүн, сонгуультан салбарын ҮЭ-ийн холбооны даргад нэр дэвших эрхтэй.
- 19.5 Анхан шатны ҮЭ-ийн хорооноос нэр дэвшигчийг бүх гишүүдийн хурлын тогтоолоор, ажлын албанаас нэр дэвшигчийг нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний тогтоолоор баталгаажуулсан байна.

Хорьдугаар зүйл. Салбарын ҮЭ-ийн холбооны даргын эрх, үүрэг

- 20.1 Салбарын ҮЭ-ийн холбооны дарга нь дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 20.1.1 Салбарын ҮЭ-ийн холбооны өдөр тутмын үйл ажиллагаа, тэргүүлэгчдийг удирдана.
 - 20.1.2 Салбарын ҮЭ-ийн холбоог гадаад, дотоодод бүрэн эрхтэй төлөөлнө.
 - 20.1.3 Салбарын ҮЭ-ийн холбооны дарга нь нарийн бичгийн дарга нараас салбарын ҮЭ-ийн холбооны даргыг орлон ажиллуулахаар Ерөнхий нарийн бичгийн даргыг томилж болно.
 - 20.1.4 МҮЭХ-ны Ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллуулах хүмүүсийн талаарх саналаа Бага хурлаар хэлэлцүүлж батлуулна.
 - 20.1.5 Тэргүүлэгчид, нарийн бичгийн даргаар ажиллуулах хүмүүсийн талаарх саналаа Гүйцэтгэх хорооны хурлаар хэлэлцүүлж батлуулна.
 - 20.1.6 Салбарын ҮЭ-ийн холбооны ажлын албаны ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг хуулийн хүрээнд байгуулж, ажилтнуудыг шагнаж урамшуулна.
 - 20.1.7 Энэхүү дүрмийн хүрээнд тодорхой асуудлаар гишүүн байгууллагад үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулна.
 - 20.1.8 Гүйцэтгэх хорооны хуралдааныг зарлан хуралдуулах асуудлыг тэргүүлэгчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.
 - 20.1.9 Тэргүүлэгчдийг нөхөн сонгох, гишүүн байгууллагыг холбооноос хасах асуудлыг Гүйцэтгэх хорооны хуралдаанд оруулна.
 - 20.1.10 Гишүүн байгууллагын тайлан, сонгуулийн хурлыг зайлшгүй шаардлагатай үед хугацаа харгалзахгүй хуралдуулж, ҮЭ-ийн хорооны даргад нэр дэвшүүлэн хэлэлцүүлнэ.
 - 20.1.11 Гүйцэтгэх хороо, тэргүүлэгчдийн хурлаас баталсан төсвийг захиран зарцуулна.
 - 20.1.12 Салбарын ҮЭ-ийн холбооны дарга нь эрхлэх ажлын хүрээнд зөвлөх ажилтныг хөдөлмөрийн гэрээгээр болон хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллуулж болно.

Хориннэгдүгээр зүйл. Салбарын ҮЭ-ийн холбооны нарийн бичгийн дарга, ажлын алба

- 21.1 Салбарын ҮЭ-ийн холбоо нь Эрчим хүчний салбар болон Геологи, уул уурхайн салбар хариуцсан нарийн бичгийн дарга нартай байх бөгөөд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд, залуучуудын төлөөллийг хангах зарчим баримтална.
- 21.2 Нарийн бичгийн дарга нарын зөвлөл нь дарга, салбар хариуцсан нарийн бичгийн дарга нараас бүрдэх бөгөөд гурав хүртэлх сая төгрөгт багтаан шагнал урамшуулал, тэтгэмж, тусламж болон үйл ажиллагаатай холбоотой зардлын асуудлыг шийдвэрлэнэ.
- 21.3 Салбарын ҮЭ-ийн холбооны ажлын алба нь бага хурал, гүйцэтгэх хорооны хуралдаан, нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөн болон холбооны удирдлагууд, гишүүн байгууллагуудын үйл ажиллагаанд үйлчилгээ, мэдээлэл, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, салбарын ҮЭ-ийн холбоог үр нөлөөтэй, тасралтгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллах үүрэгтэй.

ДОЛДУГААР БҮЛЭГ. ДОТООД ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА

Хоринхоёрдугаар зүйл. Салбарын ҮЭ-ийн холбооны Хяналтын хороо

- 22.1 Салбарын ҮЭ-ийн холбооны дотоод хяналтыг Хяналтын хороо хэрэгжүүлэх бөгөөд Бага хурлаас сонгогдоно. Бага хурлын хооронд Хяналтын хорооны гишүүдийг чөлөөлөх, нөхөн сонгох асуудлыг Гүйцэтгэх хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.
- 22.2 Хяналтын хороо 5 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй, орон тооны бус байна. Хяналтын хорооны гишүүдийг 4 жилийн хугацаатай сонгоно.

- 22.3 Хяналтын хороонд анхан шатны ҮЭ-ийн хорооны санхүүгийн захиран зарцуулах эрх бүхий ажилтан орохыг хориглоно.
- 22.4 Хяналтын хорооны даргыг Хяналтын хорооны гишүүд нууцаар санал хурааж сонгоно.
- 22.5 Хяналтын хорооны шийдвэр тогтоол байх бөгөөд дарга, гишүүд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

Хорингүравдугаар зүйл. Салбарын ҮЭ-ийн холбооны Хяналтын хорооны эрх үүрэг

- 23.1 Хяналтын хороо нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 23.1.1 Салбарын ҮЭ-ийн холбооны дүрэм, Гүйцэтгэх хорооны хуралдаан болон Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилт, ҮЭ-ийн холбооны үйл ажиллагаатай танилцаж Гүйцэтгэх хорооны хуралдаанд мэдээлэл, Бага хуралд тайлан тавьж хэлэлцүүлэх бөгөөд хяналт шалгалтын дүн, түүний мөрөөр авах арга хэмжээний тухай саналаа 14 хоногийн дотор Тэргүүлэгчдийн хуралд танилцуулж шийдвэрлүүлнэ.
 - 23.1.2 Үзлэг шалгалтыг зохион байгуулахдаа дарга, гишүүдийн 60-аас доошгүй хувь нь оролцсон байна.
 - 23.1.3 Санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина.
 - 23.1.4 ҮЭ-ийн гишүүдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн дагуу ажиллана.
 - 23.1.5 Хяналтын хороо нь дүрмээр зохицуулагдсан үүргээ биелүүлэхтэй холбогдсон асуудлаар холбогдох байгууллага хүмүүсээс мэдээлэл гаргуулж авна.
 - 23.1.6 Салбарын ҮЭ-ийн холбооны дүрмийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаа, холбооны өмч хөрөнгийн ашиглалт, эзэмшилтийг хянаж, баримтын үзлэг хийх ажлыг ажлын албанд жилд 1 удаа зохион байгуулна. Ээлжит бус үзлэгийг зохион байгуулж болно.
 - 23.1.7 ҮЭ-ийн сонгуульт ажилтны ёс зүйн асуудлыг хэлэлцэн хариуцлага тооцуулахаар холбогдох хуралд асуудал оруулж болно.
 - 23.1.8 Холбооны ҮЭ-ийн холбооны дүрмийн хэрэгжилтийг хангах, ҮЭ-ийн татварын төвлөрүүлэлтийг сайжруулах зорилгоор үндсэн нэгжийн ҮЭ-ийн хороодын дотоод ажил, санхүүгийн баримтыг шалгана.
- 23.2 Хяналтын хорооны дарга, гишүүд нь Гүйцэтгэх хорооны хуралдаанд саналын эрхгүй оролцоно.

НАЙМДУГААР БҮЛЭГ. САЛБАРЫН ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ ӨМЧ ХӨРӨНГӨ

Хориндөрөвдүгээр зүйл. ҮЭ-ийн өмч хөрөнгө

- 24.1 ҮЭ-ийн холбоо болон гишүүн байгууллагууд нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллана.
- 24.2 Үйлдвэрчний өмч хөрөнгө халдашгүй байна.
- 24.3 Төр, улс төрийн болон бусад байгууллага, ҮЭ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож үл болно.
- 24.4 Салбарын ҮЭ-ийн холбооны болон гишүүн байгууллагуудын өмч хөрөнгө нь гишүүдийн татвар, хандив ба үндсэн болон эргэлтийн хөрөнгө бусад орлогоос бүрэлдэнэ.
- 24.5 Салбарын ҮЭ-ийн холбооноос хамтын томоохон үйл ажиллагаа явуулах зорилгоор тодорхой хөрөнгийг гишүүн байгууллагуудтай зөвшилцөн төвлөрүүлэн авч болно.
- 24.6 ҮЭ-ийн өмч хөрөнгийг ашиглаж, үрэгдүүлсэн этгээдэд Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэж, хохирлыг арилгуулна. Шаардлагатай бол шүүх, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 24.7 Салбарын ҮЭ-ийн холбоо эв санааны нэгдлийн сантай байна. Энэ сан нь үйлдвэрчний эвлэлүүдийн тэмцлийн үйл ажиллагааг дэмжих, эрх зүйн тусламж, ҮЭ-ийн

ажилтнуудын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд зориулна. Сангийн ажиллах журмыг тэргүүлэгчдийн хурлаар батална.

24.8 Эв санааны нэгдлийн сан гишүүн байгуулагуудын холбоонд төвлөрүүлсэн татварын таван хувь болон хандиваас бүрдэнэ.

Хоринтавдугаар зүйл. ҮЭ-ийн гишүүний татвар

25.1 Салбарын ҮЭ-ийн холбооны гишүүн ҮЭ-ийн хороод нь ажилтны цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос сар бүр 1 буюу түүнээс дээш хувиар тогтоож ҮЭ-ийн гишүүний татварыг бэлэн бусаар хураана.

25.2 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг гишүүн ҮЭ-ийн хороо нь гишүүдээс хураасан татварынхаа 30 хувийг сар бүр Салбарын ҮЭ-ийн холбоонд төвлөрүүлнэ.

25.3 Аймаг, суманд байршилтай гишүүн ҮЭ-ийн хороо нь гишүүдээс хураасан татварынхаа зохих хувийг хариуцлага үр дүнгийн гэрээний дагуу сар бүр салбарын ҮЭ-ийн холбоонд төвлөрүүлнэ.

---oOo---